*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН А.БУРМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **"ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 1. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ"** | | | | | | | |
| 1.1.1 | Яамны стратеги болон бусад төлөвлөгөөнд санал хүргүүлэх | Боловсруулж батлуулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөө (2024-2028 он) төсөлд Салбарын хяналтын газраас хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. | 2024.02.05 2024.12.31 | 100 |
| 1.1.2 | Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг батлуулах | Боловсруулж батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | 0 | 1 | Цахим хөгжил, Харилцаа холбооны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 16-ний өдрийн А/08 дугаартай тушаалаар Салбарын хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулсан. | 2024.02.05 2024.12.31 | 100 |
| 1.1.3 | Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт, 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Салбарын хяналтын 15 улсын /ахлах/ байцаагч нийт нийт 1151 объектод эрсдэлийн ангиллын үнэлгээ хийж 2025 оны төлөвлөгөөт шалгалт хийх их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 171 объектын жагсаалтыг Засгийн газрын Хяналт, үнэлгээний үндэсний хороонд 2024.10.30-ний өдрийн 01/695 албан хүргүүлсэн. | 2024.02.05 2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн, зохион байгуулалтын удирдлагаар хангах | Шинээр боловсруулж батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | 0 | 1 | Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээлэл, харилцаа холбооны хяналтын 24 улсын (ахлах) байцаагчдыг хамруулан цахим хөгжил, харилцаа холбооны салбарын бодлого, чиглэл, хууль эрх зүй, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах нэгдсэн арга хэмжээг 2024 оны 04 дугаар сарын 03,04,05-ний өдрүүдэд зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн шударга байдлыг нэмэгдүүлэх, хувь хүний ёс зүйн манлайллыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох соён гэгээрүүлэх ажлыг асуулт хариулт, харилцан ярилцах байдлаар зохион байгуулсан нь оролцогсод бие биеэсээ харилцан туршлага судалж өөрсдийн үйл ажиллагаанд шинэ соргог зүйлсийг нэвтрүүлэх боломж олгож сургалтын ач холбогдлыг нэмэгдүүлсэн. | 2024.02.02<br>2024.06.31 | 100 |
| 1.1.5 | "Радио долгион ашиглагч этгээдийг шалгах хяналтын хуудас"-ыг шинээр батлагдсан хууль, журам, стандартын дагуу шинэчлэн боловсруулж батлуулах | Шинээр боловсруулж батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | 0 | 1 | Салбарын хяналт шалгалтын №09.03. Радио долгион ашиглагч этгээдийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг боловсруулж, оролцогч талуудаас санал авч тусган, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн А/153 дугаар тушаалаар батлуулсан. | 2024.02.02<br>2024.09.31 | 100 |
| **Зорилт 2. "Хоёр. ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 6.2.** Салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангуулах" | | | | | | | |
| 2.1.1 | Эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх | Дүн шинжилгээний тайлангийн тоо | 1 | 1 | Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 195 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар батлагдсан 09.01 Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ бүхий этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт, 09.02 Шуудан холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт, 09.03 Мэдээлэл хариуцагч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, | 2024.10.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж харьяа агентлаг, аймаг нийслэлийн хяналтын улсын байцаагч нараас санал авч дүн шинжилгээ хийсэн. 2024 онд салбарын 1151 объектод эрсдэлийн үнэлгээ хийж их-77, дунд-835, бага-239 эрсдэлтэй үнэлэгдсэн ба улсын байцаагчдад эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлж ажиллав. | | |
| 2.1.2 | Хяналт шалгалтын объектуудад эрсдлийн үнэлгээ хийхэд улсын байцаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 1 | 2024 оны эрсдэлийн ангиллын үнэлгээг 11-р сарын 01-ээс хийгдэж эхэлсэн. 2024.11.04-ний 10 цагт цахимаар аймаг, нийслэлийн Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарт Шилэн хяналтын цахим системд "Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх" сэдвээр сургалт хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан. | 2024.10.02<br>2024.12.31 | 100 |
| 2.1.3 | Салбарын эрсдэлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулж, салбарын хяналтын улсын байцаагчдад хүргүүлэх | Зөвлөмжийн тоо | 1 | 1 | 2024 оны эрсдэлийн ангиллын үнэлгээг 11-р сарын 01-ээс хийгдэж эхэлсэн. 2024.11.04-ний 10 цагт цахимаар 12 аймгийн Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарт Шилэн хяналтын цахим системд "Эрсдэлийг бууруулах арга авч ажиллах" сэдвээр сургалт хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан. | 2024.10.02<br>2024.12.31 | 100 |
| 2.1.4 | Салбарын эрсдэлийн төлөв байдал, холбогдох статистик мэдээллийг гаргах | Мэдээллийн тоо | 1 | 1 | Мэдээлэл, харилцаа холбооны хяналтаар 2024 оны хийгдсэн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт хууль сахин мөрдөлтийн хувь, эрсдэл үүсэх магадлалын хувь, зөрчил арилгуулалтын хувь, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь нийт 4 төрлийн статистик мэдээлийг гаргаж улсын байцаагч нарт танилцуулж, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан. | 2024.10.02<br>2024.12.31 | 100 |
| 2.1.5 | Хяналтын шалгалтын цахим бүртгэл www.shilenkhynalt.gov.mn системийн сайжруулалт, хөгжүүлэлтийн төслийн багийг удирдан зохион байгуулж ажиллаж, ашиглалтад оруулж нэвтрүүлэх | Цахим систем нэвтэрсэн салбар, байгууллагын тоо | 0 | 12 | Монгол улсын засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналт шалгалтын нийтлэг журам"-ийн 35.6.1-д 2023 оны 79 дүгээр тогтоолын 4 дэх заалт Засгийн газрын 2023 оны 48 дугаар хуралдааны тэмдэглэлээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд Шилэн хяналтын цахим системийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ашиглалтад оруулах, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагаа болон программ хангамж, системийн зохицуулалт, нэвтрэх эрх олгох асуудлыг хариуцах үүрэг өгсөн. Өгсөн үүрэг даалгаврын дагуу Интерактив ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр ЦХХХЯ/202310070 дугаартай Шилэн хяналт цахим системийн ашиглалтад оруулах гэрээг хийсэн. Тус гэрээний дагуу хяналт шалгалт бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (shilenkhyanalt.gov.mn) одоогийн салбарын хяналтын газруудын бүтэц, зохион байгуулалтад тохируулан Засгийн газрын хэрэг эрхлэх газар, 11 яам, 2 төрийн захиргааны байгууллагын улсын (ахлах) байцаагчид бүх төрлийн хяналт шалгалт бүртгэх, хяналт шалгалтын давхардлыг арилгах боломжтой байдлаар бүтцийн өөрчлөлтийг хийж систем нэвтрүүлэлтийн төлөвлөгөөт ажлууд хийгдсэн. | 2024.02.05<br>2024.12.31 | 100 |
| 2.1.6 | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhynalt.gov.mn үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах. | Сургалтын тоо | 0 | 14 | Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн цахим сан (shilenkhyanalt.gov.mn) нэвтрүүлэлттэй холбоотой яамны админы сургалтыг 10 удаа танхимаар 3 удаа цахимаар, 2024 оны 05 дугаар сарын 30-ний өдөр 12 яам 2 төрийн захиргааны байгууллагын улсын хэмжээний 28 хяналтын чиглэлийн нийт 1184 улсын (ахлах) байцаагчдад цахимаар "Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (shilenkhyanalt.gov.mn) системийг ашиглах зааварчилгаа өгөх, арга зүйгээр хангах" сургалтыг Интерактив ХХК, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулсан.Системд хийгдэж байгаа мэдээлэлд өдөр тутамдаа хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. | 2024.02.05<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1.7 | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийн зохицуулалт, нэвтрэх эрх олгох асуудлыг зохицуулах. | Нэвтрэх шаардлагатай байгууллагын тоо | 13 | 14 | Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн цахим сан систем (shilenkhyanalt.gov.mn) системд Засгийн газрын хэрэг эрхлэх газарт супер админы эрх 1, 11 яам, 2 төрийн захиргааны байгууллага нийт 14 админы эрхийг гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд системийн хэрэглэгчийн эрхийн дүрийн тохиргоог тохируулж өгч ажилласан. | 2024.02.05<br>2024.12.31 | 100 |
| Зорилт 2.2 Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ | | | | | | | |
| 2.2.1 | Хяналт шалгалтын үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг хийж, их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах Монгол шуудан ХХК, Юнивишн ХХК-д төлөвлөгөөт шалгалт хийх улсын ахлах байцаагчидтай хамтран хийж гүйцэтгэх. | Хууль сахин мөрдөлтийн хувь /хувь/ | 0 | 78,2 | Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооын яамны Салбарын хяналтын газрын даргын 2024 оны 7 дугаар сарын 08-ний өдрийн 09-00/12, 09-00/13, дугаартай удирдамжийн дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Цахилгаан холбоо ХК, Монгол шуудан ХК-иудын төв салбаруудад төлөвлөгөөт шалгалтын хийж гүйцэтгэлээ. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах 46 заалттай албан шаардлага хүргүүлж ажилласан. Албан шаардлагын хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй. | 2024.02.05<br>2024.12.31 | 90 |
| | | Эрсдэл үүсэх магадлал /хувь/ | 0 | 27,8 | | | |
| | | Зөрчил арилгуулалтын /хувь/ | 0 | 84 | | | |
| 2.2.2 | Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын тайлан мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийх. | Урьдчилан сэргийлэх шалгалтанд хамруулсан объектын тоо, илрүүлсэн зөрчил, авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 0 | 1 | Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын тайлан мэдээг нэгтгэж, сахин мөрдөлтийн хувь, эрсдэл үүсэх магадлалын хувь, зөрчил арилгуулалтын хувь, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь нийт 4 төрлийн статистик мэдээлийг гаргаж улсын байцаагч нарт танилцуулж, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан. | 2024.02.05<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.3 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ | 0 | 2 | 1.Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний 2024 оны 07 сарын 29-ний өдрийн 07/652 дугаартай албан бичгээр ирүүлсэн гомдол: Эрчим хүчний яамны "Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд Рутан ХХК-ий гүйцэтгэж байгаа дулааны 2А магистраль, ДХ-165 цэгээс, ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой шугамыг 2Ф500 мм-ийн голчтой болгож шугам өргөтгөх угсралтын ажлыг хийх явцад холбооны сувагчлал эвдсэн, дахин ашиглах боломжгүй болсон асуудалд Харилцаа холбооны тухай хууль, Барилгын тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, норм, стандартын мөрдөлтийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах 2024.08.21-ний өдрийн 09-00-03/002/05 дугаартай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулан Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-г хохирлыг барагдуулж ажилласан.<br>**2. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний 2024 оны 08 сарын 28-ний өдрийн 07/733 дугаартай албан бичгээр ирүүлсэн гомдол:** Баянгол дүүргийн 3 дугаар хороо 22, 23, 24, 37-р байруудын суурин дээр үйлчилгээтэй орон сууцны барилгын ерөнхий гүйцэтгэгч "Орчлон Констракшн" ХХК нь С блокийн барилгын суурийн ажил гүйцэтгэх явцдаа харилцаа холбооны худаг сувагчлалын байгууламжийг эвдэж гэмтээсэн асуудалд төлөвлөгөөт бус шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах 09-00-02/002/06 дугаартай улсын байцаагчийн 3 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан. | 2024.02.05<br>2024.12.31 | 100 |
| **3.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Хүлээлгэн өгсөн архивын нэгж | 0 | - | 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу Салбарын хяналтын газрын төлөвлөгөө, тайлан хяналт шалгалтын баримт бичиг нийт 3 архивын нэгж үүсгэн байгууллагын архивт шилжүүлэхээр бэлтгэж байна. | 2024.02.05 2024.12.31 | 100 |
| | | Хасхомын тайлагналт | 0 | 1 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргаж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд тайлагнаж баталгаажуулсан. | 2024.02.05 2024.12.31 | 100 |
| 3.2 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, байгууллагын цахим болон дотоодын ээлжит, ээлжит бус шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах | Тухайн жилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/ | 0 | 100 | Тайлант хугацаанд нийт 30 албан бичиг, 1 өргөдөл гомдол ирсэн байна. Дээрх 30 албан бичгээс 20 нь хариугүй, 10 нь хариутай байх бөгөөд үүнээс 8 нь хууль, журмын төсөлд санал авах, 2 нь тодруулга авах асуудлаар гаргасан албан бичгүүд байна. Дээрх албан бичгүүдээс 9 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 1 албан бичиг хяналтад байна. Өргөдөл гомдлын тухайд хүлээн авсан 1 өргөдлөөс 1 өргөдлийг хуулийн хүрээнд шийдвэрлэж иргэнд хуульд заасан хугацаанд албан бичгээр хариу өгсөн. Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%. | 2024.02.05 2024.12.31 | 100 |
| 3.3 | Тайлан мэдээ гаргаж хүргүүлэх | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Газрын 7 хоног, сарын болон хагас, бүтэн жилийн ажлын тайланг нэгтгэн гаргаж, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан. | 2024.02.05 2024.12.31 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн, зохион байгуулалтын удирдлагаар хангах | - | - | - | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн А/57 дугаартай Гэрээ байгуулах, зардал гаргах тухай тушаал боловсруулж батлуулан тушаалын хавсралт Сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулсан. | 2024.03.25<br>2024.04.01 | 100 |
| 2. | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhynalt.gov.mn үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах. | - | - | - | Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн ерөнхий газрын 2024.04.16 өдрийн 1/934 дугаартай албан бичгийн дагуу аймаг, нийслэлийн нийт 35 Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн хяналтын улсын байцаагчдад Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhynalt.gov.mn үйл ажиллагаатай ажиллах зааварчилгаа сургалт хийсэн. | 2024.04.25 | 100 |
| 3 | | - | - | - | Эрүүл мэндийн яамны 2024 оны 5 дугаар сарын 06 өдрийн 9/1928 дугаартай албан бичгийн дагуу аймаг, нийслэлийн нийт 212 эрүүл мэндийн чиглэлийн хяналтын улсын байцаагчдад Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhynalt.gov.mn үйл ажиллагаатай ажиллах зааварчилгаа сургалт хийсэн. | 2024.05.10 | 100 |
| 4 | | - | - | - | Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны 2024.12.04 өдрийн 3/1247 албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Соёлын хяналтын улсын 74 байцаагчид Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhynalt.gov.mn үйл ажиллагаатай ажиллах зааварчилгаа сургалт хийсэн. | 2024.12.05 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах | Амжилттай суралцсан кредит цаг | 0 | 8 | Удирдлагын академийн дунд хугацааны давтан сургалтад хамрагдаж сертифкат авсан. | 2024.02.05 2024.12.31 | 100 |
| 2. | Монгол бичиг бие даан суралцах | Амжилттай суралцсан кредит цаг | 0 | 40 цаг | Удирдлагын академаас зохион байгуулсан Монгол бичгийн анхан шатны цахим сургалтад хамрагдаж үнэмлэх авсан. | 2024.02.05 2024.12.31 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Эрхлэгч Мэргэжилтэн ................ ( Албан тушаал )

А.Зурмаа / А.Зурмаа ................ ( Нэр, гарын үсэг )

2024.12.10 ................ ( Огноо )